



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

“Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 -ын “ж” дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 20 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01/2570 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсугай.


2. “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 25 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Р.ДАГВА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны ... дугаар сарын ...ний  
өдрийн ... дүгээр тогтоолын хавсралт



## “ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хот байгуулалтын салбарт дэмжлэг үзүүлэх, зураг төсөл, судалгааны материалаар хангах чиг үүрэг бүхий өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бие даасан хуулийн этгээд мөн.

1.2. “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (цаашид “үйлдвэрийн газар” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

### Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа газар

2.1. Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Хот төлөвлөлт, судалгааны институт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бөгөөд товчилсон нэр нь “ХТСИ” ОНӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газрын байршил нь тухайн хуулийн этгээдийн байрлаж байгаа хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг удирдлага нь тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.3. Үйлдвэрийн газар нь албан ёсны шуудан болон цахим хаягтай байх бөгөөд ба үйлдвэрийн газрын байршил, шуудан болон, цахим хаягийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлнэ.

### Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг

3.1. Үйлдвэрийн газар нь албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Үйлдвэрийн газар нь бэлгэдэл (эмблем)-тэй байж болно. Бэлгэдлийн загварыг Удирдах зөвлөл баталж, түүнийг ашиглах эрхийг үйлдвэрийн газар эдлэнэ.

3.3. Үйлдвэрийн газрын тамгаар тус байгууллагын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4. Тамга, тэмдгийг үйлдвэрийн газрын захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Дөрөв. Үйлдвэрийн газрын эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулах хугацаа

4.1. Үйлдвэрлэлийн газрын эрхэм зорилго нь түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж Хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.

4.2. Үйлдвэрийн газар нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

4.2.1. Хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх. Үүнд:

- 4.2.1.1. газар нутаг, хүн амын судалгаа;
- 4.2.1.2. эдийн засаг, хөрөнгө оруулалтын судалгаа,
- 4.2.1.3. нийгэм, соёлын судалгаа;
- 4.2.1.3. зам тээвэр, инженерийн дэд бүтцийн судалгаа;
- 4.2.1.4. байгаль орчин, аюулгүй байдлын судалгаа;
- 4.2.1.5. газар ашиглалт, барилгажилтын судалгаа;
- 4.2.1.6. шаардлагатай бусад судалгаа.

4.2.2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах. Үүнд:

- 4.2.2.1. хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл;
- 4.2.2.2. бүсийн хөгжлийн төсөл;
- 4.2.2.3. чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө;
- 4.2.2.4. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
- 4.2.2.5. хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- 4.2.2.6. шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө;
- 4.2.2.7. барилга байгууламжийн зураг төсөл;
- 4.2.2.8. хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;
- 4.2.2.9. хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл.

4.2.3. Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулна.

4.3. Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахад эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

4.4. Үйлдвэрийн газар нь байгууллагын эрхэм зорилгод нийцсэн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

4.5. Үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт орсон тохиолдолд хууль, тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.



4.6. Үйлдвэрийн газрыг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаатай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

4.7. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйлдвэрийн газрыг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

4.8. Байгууллага, байгууллагын удирдлага, ажилтнууд эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууц, байгууллагын нууцыг чанд хадгалах ба түүнийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэхийг хориглоно.

#### Тав. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүрэг

5.1. Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээнэ. Үүнд:

5.1.1. Өөрт олгогдсон үл хөдлөх эд хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

5.1.2. Эргэлтийн бус хөрөнгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

5.1.3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заасан татвар хураамжийг төлсний дараа үлдэх цэвэр ашгийн ... хувийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан зориулалтын тусгай санд төвлөрүүлж үлдэх хэсгийг үйлдвэрийн газрын захирлын баталсан журмын дагуу захиран зарцуулах;

5.2. Энэхүү дүрмийн 5.1.3-т заасны дагуу зориулалтын тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгийг зөвхөн нийслэлийн удирдлагаас Үйлдвэрийн газарт захиалгаар ажил гүйцэтгүүлэх болон хот байгуулалтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулах зориулалтаар ашиглана.

#### Зургаа. Үйлдвэрийн газрын удирдлага


6.1. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Захирал удирдана. Үйлдвэрийн газрын захирлыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.2. Үйлдвэрийн газрын захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

6.3. Үйлдвэрийн газрын Захирал нь Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллах бөгөөд түүний өмнө гэрээний биелэлтийг хариуцна.

6.4. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

6.5. Үйлдвэрийн газарт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилогдсон Удирдах зөвлөл нь төлөөлөл хэрэгжүүлэн, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.



6.6. Удирдах зөвлөл нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.7. Үйлдвэрийн газрын Захиралд зөвлөх үүрэг бүхий захирлын зөвлөлийг ажиллуулж болно.

6.8. Үйлдвэрийн газрын Захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:

6.8.1. холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх;

6.8.2. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.8.3. үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

6.8.4. батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн дотоод журмыг тогтоож мөрдүүлэх, ажилтнуудыг ажилд томилох, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;

6.8.5. ажлын байрны тогтмол болон жишиг цалингийн хэмжээ тогтоох, үйл ажиллагааны онцлогт тохирсон урамшууллын журам баталж мөрдөх;

6.8.6. гадаад, дотоодод болон маргаантай асуудлаар шүүх, арбитрын байгууллагад үйлдвэрийн газрыг төлөөлөх;

6.8.7. өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар тушаал гаргаж, холбогдох дүрэм журам, заавар баталж, биелэлтийг нь зохион байгуулж, үр дүнг тооцох;

6.8.8. үйлдвэрийн газрын тухайн жилийн /үеийн/ төсөв, захиалгат ажлын тоо хэмжээнээс хамаарч санхүүгийн нөхцөл байдалд хүндэрсэн тохиолдолд ажилтнуудыг түр чөлөөлөн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон олгож эрүүл мэнд, нийгмийн даатгалыг төлөх;

6.8.7. хууль, тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг.

6.9. Хот, төлөвлөлт, дэд бүтэц, инженерийн шийдэл, шинэ технологи, судалгаа шинжилгээний чиглэлээр оновчтой шийдэл гаргах зорилго бүхий орон тооны бус техникийн мэргэжлийн зөвлөлтэй байна. тус зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг Захирлын тушаалаар батална.

6.10. Захирал хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн эрх үүргийг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрх, үүргээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Долоо. Үйлдвэрийн газрын хяналт

7.1. Үйлдвэрийн газар нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг Захирал батална.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар хяналт, тавина.



7.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг Ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Найм.Үйлдвэрийн газрын санхүүжилт, санхүү, бүртгэлийн тайлан

8.1.Үйлдвэрийн газрын тухайн жилийн орлого нь санхүүгийн дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

8.1.1.Улсын болон орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт;

8.1.2.зохиогчийн хяналтын зардал;

8.1.2.ажил, үйлчилгээнээс олсон орлого;

8.1.6.гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламж;

8.1.7.олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олох үйлчилгээний орлого;

8.1.8.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

8.2.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.3.Байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

8.4.Үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

8.5.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулна.

8.6.Үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэстэй зөвшилцөж Захирал томилно.

8.7.Нийслэлийн Засаг даргатай байгуулсан контрактын биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлнэ.

Ес.Үйлдвэрийн газрын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

9.1.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

9.1.1.Баланс;

9.1.2.үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан;

9.1.3.мөнгөн гүйлгээний тайлан;


9.1.4.өмчийн өөрчлөлтийн тайлан;

9.1.5.тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

9.1.6.нэмэлт тайлбар;

9.1.7.санхүүгийн тайлангийн тодруулга;

9.1.8.бусад.



9.2.Захирал нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга, Өмчийн ашиглалт, удирдлагын газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнг улирал бүр тайлагнах ба тайланд тайлангийн хугацаанд олгосон шагнал урамшуулал, нийгмийн халамж, удирдлагын зардлын хэмжээ болон шаардлагатай бусад мэдээллийг тусгасан байна.

#### Арав.Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

10.1.Үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална.

10.1.1.Үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, үйлдвэрийн газрыг байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, холбогдох бусад бичиг баримтууд;

10.1.2.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж;

10.1.3.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгасан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

10.1.4.улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын захиалгын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон тэдгээртэй холбоотой гаргасан хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, гэрээ, хэлцэл, холбогдох бусад бичиг баримт;

10.1.5.үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, холбогдох бусад бичиг баримтууд;

10.1.6.хурлын тэмдэглэл, шийдвэр, даргын тушаал, шийдвэрүүд;

10.1.7.бусад ач холбогдол бүхий бичиг баримтууд.

10.2.Дүрмийн 10.1-т заасан бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажлыг даргын туслах, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

#### Арван нэг.Үйлдвэрийн газрыг татан буулгах

11.1.Үйлдвэрийн газрыг татан буулгах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх ба Иргэний хууль болон бусад хуульд заасан журмыг баримтална.

#### Арван хоёр.Бусад асуудал

12.1.Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

12.2.Үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

12.3.Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцно.

12.4.Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

